



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/139

Хэрлэн сум

Агаарын хөлгийг шувуу, мал амьтантай
мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх
салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66 дугаар зүйлийн 66.3 дахь заалт, Зам тээврийн яамны сайдын 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 95 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн хэмжээнд Агаарын хөлгийг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын орлогч

Нисэх буудлын дарга

Цэргийн штабын дарга

Мэргэжлийн хяналтын газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Мал эмнэлгийн газрын дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч

Цахилгаан түгээх сүлжээ салбарын захирал

2.Салбар зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3.Агаарын хөлгийг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Салбар зөвлөлийн дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хэнтий аймгийн Засаг даргын 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/313 дугаар "Агаарын хөлгийг шувуу, мал

• 231010386

2.

амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөл байгуулах тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

АГААРЫН ХӨЛӨГ, ШУВУУ, МАЛ, АМЬТАНТАЙ МӨРГӨЛДӨХ АЮУЛААС СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг: Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмаар “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл” /цаашид салбар зөвлөл гэх/-ийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Салбар зөвлөл нь агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулыг бууруулах талаар зөвлөмж, шийдвэр гаргах аюулаас сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилтэнд үнэлэлт өгөх, энэ талын үйл ажиллагаатай холбоотой төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэгтэй орон тооны бус нэгж юм.

1.3 Салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, Иргэний нисэхийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Аэродромын стандарт, ИНД болон бусад хууль тогтоомж, стандартыг удирдлага болгоно.

1.4 Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг нисэх буудлын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Хоёр: Салбар зөвлөлийн зохион байгуулалт

2.1 Салбар зөвлөлийн ажиллах хэлбэр нь хурал байх бөгөөд хурлаас гаргасан шийдвэр нь зөвлөмж эсхүл үүрэг даалгавар хэлбэртэй байна.

2.2 Салбар зөвлөлийг жилд 2 удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухай үед нь зарлан хуралдуулна.

2.3 Зөвлөлийн гишүүдийн 50% оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох ба хурлыг салбар зөвлөлийн дарга даргалж хурлын дэгийг мөрдүүлнэ.

2.4 Салбар зөвлөлийн хурлын шийдвэр нь олонхийн саналд үндэслэнэ. Санал тэнцсэн тохиолдолд салбар зөвлөлийн даргын саналаар шийдвэр гаргана.

Гурав: Салбар зөвлөлийн үндсэн үүрэг

3.1 Салбар зөвлөл нь “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, зохицуулах, зохион байгуулах үндсэн үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1 Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх, осол, зөрчил сүйрлээс сэргийлэхэд төрийн, төрийн бус, болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн анхаарлыг хандуулах, тэдгээрийн хамтын ажиллагааг сайжруулах

3.1.2 Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэхтэй холбоотой гарын авлага гаргах ба холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэх

3.1.3 Нисэх буудлын аэродромын аюулгүй бүсэд тохиолдох шувуу, зэрлэг амьтдын тандалт судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, үүсч болох эрсдлийг урьдчилан тооцож, арилгах арга хэмжээ авах

Дөрөв: Хэлэлцэх асуудал, салбар зөвлөлийн эрх

4.1 Салбар зөвлөл нь дор дурьдсан асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргах эсхүл хурлын тэмдэглэлээр үүрэг даалгавар өгнө. Үүнд:

4.1.1 Агаарын хөлөг, шувуу мал амьтантай мөргөлдөх эрсдлийн үнэлгээ

4.1.2 Шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулыг бууруулахаар хэрэгжүүлж байгаа ажил, үр дүн, тайлан

4.1.3 Нисэх буудлын хэтийн төлөв болон аюулгүйн бүсийн газар ашиглалт нь Хэнтий аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан эсэх талаархи сонсгол

4.1.4. Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдсөн мэдээлэл, тайлан

Тав: Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын хүлээх үүрэг

5.1 Салбар зөвлөлийн гишүүд үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг ханган ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах

5.2 Салбар зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмж, шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

5.3 Салбар зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангаж хурлыг зохион байгуулах

5.4 Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хуралд хэлэлцүүлэх